



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2023.03.01- 2023.03.31 ХҮРТЭЛ ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Тайлангийн дугаар: Хяналт/2023/09


Хэвлэсэн огноо: 2023.04.14

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Тус хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвөөс Улаанбаатар хотын хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын радио давтамжийн суурин хэмжилтийг стандартын шаардлагыг хангуулах, технологийн норм, горимыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор тогтмол хийж байна.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд	Харилцаа холбооны зохицуулах хорооны төв оффис, Метро бизнес төв А-блок 5 давхар, Д.Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг,	/106°54'53.8"E 47°55'38.2"N/



Зураг 1. Хэмжилт хийсэн цэг

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

KFSMS-2014 суурин хяналтын станц. /CN01162391/

4. Норматив бичиг баримт:


MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы нэвтрүүлэгч (VHF), техникийн шаардлага”

5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:


Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	М.Болдбат	ХХЗХ, РДӨНХТ	Суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:


Тайлант хугацаанд төвийн давтамжийн хазайлт, төвийн давтамжийн шилжилт, эзэлсэн зурвасын өргөн гэсэн үндсэн үзүүлэлтээр хэмжигдсэн 33249 удаагийн хэмжилтийг нэгтгэн боловсруулж дундаж утгыг график хэлбэрээр Зураг 2, Зураг-3, Зураг-4-т үзүүлэв. Үүнд:



Зураг 2. Давтамжийн хазайлт



Зураг 3. Давтамжийн шилжилт



Зураг 4. Эзэлсэн зурвасын өргөн

7. Хэмжилтийн дүн:

Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвөөс радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийж байна. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 36 аж ахуйн нэгжид 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд суурин хяналт хийснээс 8 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн давтамжийн хазайлтын дундаж утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, эдгээрээс 1 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн төвийн давтамжийн шилжилтийн дундаж утга болон эзэлсэн зурвасын өргөний дундаж утга стандарт хэмжээнээс хэтэрсэн, 2 радиогийн үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаагаа түр зогсоосон, 26 радиогийн үйлчилгээ эрхлэгч хэвийн ажиллаж байна.

7.1. Стандартын шаардлагыг хангасан:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы нэвтрүүлэгч (VHF), техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн модуляцтай дохионы давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх шилжилт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг хангасан дараах радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үүнд:

№	ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	ФМ-ИЙН НЭР	ДАВТАМЖ /МГц/
1	Эм Жи Эл Радио ньус ХХК	22800192	Эм Жи Эл Радио Ньюс	88.3
2	СКОД ХХК	22800167	Medeemn FM-88.8	88.8
3	Сета тех ХХК	22800193	Аялгуу	89.3
4	Жавзандамба хутагт төв ТББ	22800186	Зохист аялгуу ФМ	89.7
5	Улаанбаатар телевиз ХХК	22800178	VIP радио	90.5
6	Монгол комикс ХХК	22800159	Цаг үе залуус	91.1
7	Скаймедиа групп ХХК	22800146	Стар ФМ 92.5	92.5
8	*Шинжлэх ухаан технологийн их сургууль ТӨАГУТУГ	22800206	ШУТИС-ын радио	94.1
9	*Монкаст радио ХХК	22800194	Ухаалаг ФМ94.5	94.5
10	Шүхэр ТББ	22800117	Хамаг Монгол FM-95.1	95.1

11	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	Авто радио	96.3
12	Эх элгэн нутаг ХХК	22800114	Элгэн нутаг FM	96.9
13	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд	22800071	Лавайн эгшиг FM	97.5
14	Радиоком Монгол ХХК	22800025	Формула FM	98.1
15	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	22800029	Best FM	98.5
16	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	Бизнес радио	98.9
17	Нью медиа ХХК	22800026	Инээмсэглэл FM-99.3	99.3
18	Билэгт дөлгөөн ХХК	22800060	Их Монгол FM	99.7
19	РФ ХХК	22800005	Kiss radio 100.1	100.1
20	НС Холбоо ХХК	22800040	Гийнгоо FM 100.5	100.5
21	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	Радиогийн 3-р програм	100.9
22	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	Монголчуудын радио 102.1	102.1
23	Бадруун ХХК	22800006	Радио УБ FM-102.5	102.5
24	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	BBC	103.1
25	Салхи Энтертейнмент ХХК	22800057	Гэр бүлийн радио	104.5
26	Чугу ХХК	22800037	Vibe FM 105.5	105.5
27	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	Радиогийн 1-р програм	106.0
28	И Зэт Эф Эм ХХК	22800038	Эх дэлхий ФМ	107.0

* Шинжлэх ухаан технологийн их сургууль ТӨАГУТҮГ-ын 94.1 МГц радио, Монкаст радио ХХК-ийн 94.5 МГц радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч техникийн засвар үйлчилгээ хийж байгаа тул үйл ажиллагаагаа түр зогсоосон байна.

7.2. Стандартын шаардлагыг хангаагүй:

MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй давтамжийн модуляцтай дохионы давтамжийн хазайлт /Deviation/-ын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн дараах радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх шаардлагатай байна. Үүнд:

№	ЭЗЭМШИГЧ	ЗӨВШӨӨРӨЛ	ФМ-ИЙН НЭР	ДАВТАМЖ /МГц/
1	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	Метро лоунж	91.7

2	Смарт коммунікэйшн ХХК	22800158	Тойм FM-92.1	92.1
3	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	Арга билиг FM	95.7
4	Агрегатор ХХК	22800022	Тэргүүлэгч FM-101.7	101.7
5	Медиа холдинг ХХК	22800009	Тэнгэрлэг радио FM-103.6	103.6
6	Ви Өү Эм ХХК	22800052	Эрүүл амьдралын радио	104.0
7	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	Америкийн дуу хоолой	106.6
8	Билэг санаа ХХК	22800018	Шинэ долгион FM-107.5	107.5

Эдгээрээс нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх шилжилт /Offset/ 2 кГц, эзэлсэн зурвасын өргөн /Occupied BW xdB/ 300 кГц-ээс хэтэрсэн Ви Өү Эм ХХК-ийн 104.0 МГц радиогийн үйлчилгээ эрхлэгч нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх шаардлагатай байна.

8. Дүгнэлт:

Радио станцуудын тархалтын болон сонсголын чанар нь тухайн радиогийн үйлчилгээ эрхлэгчийн нэвтрүүлэх хэсэгт ашиглаж буй дууны холигч пульт, түүгээр дамжуулагдаж буй дууны түвшингээс ихээхэн хамаарч байна. Иймд хүлээн авах талд сонсогдож, хэмжигдэж буй дууны зөөгч давтамжийн хазайлтыг хэвийн байлгах, сонсголыг сайжруулахын тулд дууны пультны тохиргоог стандарт хэмжээгээр тохируулж нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх, зориулалтын дуу бичлэгийн студид контентоо бэлтгэх шаардлагатай байна.